



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
ТЭМДЭГЛЭЛ**

2015 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Өргөдлийн байнгын хорооны 2015 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны тэмдэглэл:

Хэлэлцсэн нь:

Нийслэлийн 84 дүгээр сургуулийн багш, ажилчид болон суралцагчдын эцэг, эхчүүд болох нийт 3370 иргэнээс тус сургуулийн давхар нэмэх өргөтгөлийн төсвийг нэмэгдүүлэн сургуулийн дэргэд өргөтгөлийн барилга барих асуудлыг шийдвэрлүүлэх.

Шийдвэрлэсэн нь:


Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т дараах чиглэлийг өгөх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1.Өргөдөл гаргасан иргэдийн хүсэлт болон Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 1а/1442 тоот албан бичигт дурдсанаар 84 дүгээр сургуулийн одоо байгаа барилга дээр давхар нэмэх бус тус сургуулийн эдэлбэр газар дээр шинээр зураг төсөл боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2015 оны төсвийн тодотголд тусган барилгын ажлыг эхлүүлэх, шаардлагатай бол цаашид улсын төсөвт санхүүжилт нэмж тусган хэрэгжүүлэхийг Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгохоор тогтов.

2.Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу 2015 оны хаврын чуулганы хугацаанд холбогдох арга хэмжээг авч, тус Байнгын хорооны хуралдаанд танилцуулах.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



О.БААСАНХҮҮ

Г.НЯМСҮРЭН